



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/422

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.1.5 дахь заалт аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7 дахь хэсэг, Говь-Алтай 80+ эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд "БАТ ГЭРЭЛТ НҮТББ" академитай байгуулсан захиалгат гэрээг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргасугай.

2. Шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд төсөвлөгдсөн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал) Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О. АМГАЛАНБААТАР

